МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2026.02.24 № 11

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

Улсын Их Хурлын 2025 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 57 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан дараах асуулгыг Танд тавьж байна.

1.Тогтоолд тусгасан Засгийн газрын хэрэгжүүлэх 17 арга хэмжээнээс өнөөдрийн байдлаар бүрэн хэрэгжсэн, хэрэгжих шатанд байгаа болон бодит ахиц гараагүй арга хэмжээнүүдийг ялган тодорхойлж, арга хэмжээ тус бүрийг “хариуцсан байгууллага, хэрэгжилтийн үе шат, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулсан төсөв, бодит үр дүн” гэсэн агуулга бүхий нэгдсэн хүснэгт, тайлбар мэдээлэл;

2.Тогтоолд заасны дагуу ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ногоон зээлийн зохицуулалт, ногоон барилгын шалгуур, эрчим хүчний хэмнэлтийн стандарт, “Хэмжих-Хянах-Тайлагнах” тогтолцоог бий болгох чиглэлээр Засгийн газраас тодорхой хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулах үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомж болон салбарын яамдаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн тогтоолууд, батлагдсан эсэх, хэрэгжилтийн явцын талаарх бодит мэдээлэл, мөн боловсруулалтын шатанд байгаа эрх зүйн баримт бичгүүдийн талаарх мэдээлэл, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн бодит хугацаа, уг баримт бичгүүд бодлогын хувьд ямар өөрчлөлт, үр нөлөө үзүүлэхээр тооцоолсон талаарх төлөвлөгөө бүхий тайлан, мэдээлэл;

3.Ногоон санхүүжилтийг бодит эдийн засгийн механизм болгон хэрэгжүүлэх зорилтын хүрээнд хамрагдсан банк, санхүүгийн байгууллагуудын талаар, мөн ногоон зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүд, тэдний хамаарах салбар, бүс нутгийн байршил, олгогдсон зээлийн нийт хэмжээ, түүнчлэн ногоон зээлийн хүүгийн бодлого бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж, дундаж хүү өмнөх үетэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн, улсын төсвөөс хүүгийн татаас, дэмжлэг хэлбэрээр хэдий хэмжээний санхүүжилт олгосон, 2026 онд олгох зээлийн талаар бодит тоон үзүүлэлт бүхий нэгдсэн мэдээлэл;

2026009031

4.Эрчим хүчний хэмнэлт, дулаалгын бодлогоор хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд хамрагдсан нийт өрхийн тоо, энэ нь жилд хичнээн Гкал дулаан, МВт.ц цахилгаан хэмнэж байгаа, үүний үр дүнд агаарын бохирдлын түвшинд бодитоор өөрчлөлт гарсан талаарх тоон үзүүлэлт, тооцоолол бүхий судалгаанд тулгуурласан мэдээлэл байгаа эсэх;

5.Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын түвшинд нэгдсэн зохицуулалтын бүтэц, тухайлбал ажлын хэсэг, зөвлөл, дэд хороо зэргийг байгуулж ажилласан эсэх, бодлогын уялдаа холбоог төвлөрсөн байдлаар хариуцаж ирсэн ямар байгууллага байгаа талаарх тодорхой мэдээлэл, хэрэгжилтийн явцад тулгарсан эрх зүйн зохицуулалтын саад, санхүүжилтийн хүндрэл, институц хоорондын давхардал, уялдаа холбоо сул зэрэг бодит бэрхшээлүүдийн талаар Засгийн газрын зүгээс хийсэн үнэлгээ, дүгнэлт;

6.Цаашид 2026–2028 онд ногоон санхүүжилтийн тогтолцоог эдийн засгийн салбарын бодит механизм болгох, иргэн, аж ахуйн нэгжид бодитоор хүртээмжтэй болгох, хотын агаарын бохирдол, эрчим хүчний хэрэглээнд хэмжигдэхүйц нөлөө үзүүлэх чиглэлээр Засгийн газраас баримтлах төлөвлөгөө, зорилт, шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны бодлогын талаарх тодорхой мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан бичгээр ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлэх бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжвэл асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦ

2026009031